



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2023/12/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 05	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/65
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Г **БАЯНХОНГОР СУМЫН БАЯН-ОЙТ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Л.АЮУРЗАНА ТАНАА** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Боловсролын мэдээллийн технологийн төвөөс бүх сургууль цэцэрлэгийн интернэтийн төлбөр 100 хувь төлсөн байхад тухайн байгууллага нь тайлант онд 3,171.6 мянган төгрөгийг Мобиком ХХК руу интернэтийн төлбөрт төлсөн байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

005020295

D/2023-A4 Alban toot

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,795,307.53	217,592,558.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	127,407,818.10
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	127,407,818.10
31210	Төгрөг	-	127,407,818.10
31211	Төрийн сангийн харилцах	-	127,407,818.10
33	АВЛАГА	786,367.57	0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	786,367.57	0
35	БАРАА МАТЕРИАЛ	91,008,939.96	90,184,740.16
35100	Түүхий эд материал	5,322,992.00	6,218,926.40
35110	Тусгай зориулалттай материал	-	5,627,724.40
35130	Эм боох материал	5,322,992.00	591,202.00
35400	Хангамжийн материал	85,685,947.96	83,965,813.76
35410	Бичиг хэргийн материал	3,392,500.00	2,687,500.00
35420	Аж ахуйн материал	38,558,676.13	45,921,676.13
35440	Түлш, шатах тослох материал	700,000.00	0
35450	Барилгын засварын материал	6,384,605.00	1,044,605.00
35460	Хүнсний материал	58,915.01	20,000.01
35470	Бусад хангамжийн материал	36,591,251.82	34,292,032.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,053,957,441.10	2,031,605,170.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,053,957,441.10	2,031,605,170.16
39200	Биет хөрөнгө	2,053,957,441.10	2,031,605,170.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,053,020,473.00	2,053,020,473.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,010,425.73)	-126,246,144.41
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	137,447,847.19	170,443,960.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,345,791.39)	-98,124,165.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,641,917.03	89,005,589.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,163,619.55)	-70,041,582.87
39217	Ном	13,367,040.55	13,547,040.55
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,145,752,748.63	2,249,197,728.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	94,232.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	94,232.55
41300	Өглөг	-	94,232.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	94,232.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,145,752,748.63	2,249,103,495.87
51	Засгийн газрын хувь оролцоо	2,145,752,748.63	2,249,103,495.87
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,225,483.90	
511002	Орон нутгийн оруулсан хөрөнгө	-	52,225,483.90
51200	Хуримтлагдсан үр дүн	2,009,390,590.73	2,112,741,337.97
51210	Өмнөх үеийн үр дүн	2,009,390,590.73	2,009,390,590.73
51220	Тайлант үеийн үр дүн		103,350,747.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,136,674.00	84,136,674.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,145,752,748.63	2,249,197,728.42

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	790,311,838.00	1,171,363,709.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,232,700.00	36,982,509.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,232,700.00	36,982,509.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	490,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	490,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	36,492,509.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,079,138.00	1,134,381,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	621,342,300.00	939,246,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	939,246,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	621,342,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,929,203.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,929,203.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,807,635.00	195,134,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,807,635.00	195,134,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	818,011,444.54	1,068,012,962.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,011,444.54	1,068,012,962.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,040,411.96	913,454,760.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,028,926.10	573,541,600.89
210101	Үндсэн цалин	410,633,926.10	387,463,702.07
210102	Нэмэгдэл	40,176,700.00	127,329,906.57
210104	Урамшуулал	22,218,300.00	34,052,392.25
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	24,695,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,823,813.69	71,343,108.28
210201	Тэтгэврийн даатгал	48,086,413.69	48,603,233.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,934,800.00	5,648,930.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,300.00	4,651,227.67
210204	Ажилгүйдлийн даатгал	586,600.00	1,388,421.79
210205	Эрүүл мэндийн даатгал	5,868,700.00	11,051,294.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,677,635.00	138,493,053.03
210301	Гэрэл, цахилгаан	5,918,194.00	10,916,160.03
210302	Түлш, халаалт	114,691,005.00	121,317,597.00
210303	Цэвэр, бохир ус	5,068,436.00	6,259,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,416,493.79	17,765,709.20
210401	Бичиг хэрэг	5,962,502.51	6,561,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,587.22	2,280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	911,121.06	197,890.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	00.00

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,707,420.00	6,427,600.00
210408	Бараа материал акталсны зардал	1,714,863.00	2,299,219.20
2105	Нормативт зардал	9,498,961.00	4,731,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,498,961.00	4,731,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,841,400.00	21,570,000.00
210604	Урсгал засвар	8,841,400.00	21,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,150,963.00	6,197,842.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,010,713.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	140,250.00	6,197,842.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,602,219.38	79,811,656.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,495.00	14,656,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,369,800.00	4,263,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,188,924.38	60,892,056.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,971,032.58	154,558,201.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,458,425.00	143,099,255.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,125,835.00	127,815,255.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,232,590.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	15,284,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	11,458,946.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,458,946.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,512,607.58	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,512,607.58	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,699,606.54	103,350,747.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	143,399.57	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	143,399.57	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-143,399.57	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,843,006.11	103,350,747.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	789,079,138.00	1,134,871,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	490,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	490,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	490,000.00

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	490,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,079,138.00	1,134,381,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	621,342,300.00	939,246,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	939,246,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	621,342,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,929,203.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,929,203.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,807,635.00	195,134,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,807,635.00	195,134,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	774,317,738.00	999,788,381.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,317,738.00	999,788,381.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,609,355.42	845,269,094.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,048,200.00	572,416,836.62
210101	Үндсэн цалин	391,092,500.00	386,433,161.38
210102	Нэмэгдэл	49,914,100.00	127,327,278.93
210104	Урамшуулал	30,041,600.00	33,960,796.31
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	24,695,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,535,916.36	71,587,272.43
210201	Тэтгэврийн даатгал	47,022,616.36	48,192,880.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,878,300.00	5,932,310.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,102,700.00	4,749,419.63
210204	Ажилгүйдлийн даатгал	775,700.00	1,414,212.91
210205	Эрүүл мэндийн даатгал	7,756,600.00	11,298,448.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,677,635.00	138,493,053.03
210301	Гэрэл, цахилгаан	5,918,194.00	10,916,160.03
210302	Түлш, халаалт	114,691,005.00	121,317,597.00
210303	Цэвэр, бохир ус	5,068,436.00	6,259,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,783,251.06	00.00
210401	Бичиг хэрэг	1,646,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,641.06	00.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	817,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,525,610.00	00.00
2105	Нормативт зардал	13,565,800.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,965,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,130,000.00	17,400,000.00
210604	Урсгал засвар	20,130,000.00	17,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,248,753.00	7,692,342.85

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,010,713.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	238,040.00	7,692,342.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,619,800.00	37,679,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	25,924,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,719,800.00	11,755,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,708,382.58	154,519,286.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,195,775.00	143,060,340.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,863,185.00	127,776,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,232,590.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	15,284,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	11,458,946.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,458,946.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,512,607.58	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,512,607.58	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,761,400.00	135,082,818.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,761,400.00	7,675,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,761,400.00	7,675,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,761,400.00	7,675,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,761,400.00	7,675,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,761,400.00	-7,675,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	127,407,818.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	127,407,818.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	2,173,595,754.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	2,173,595,754.74
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,843,006.11	-27,843,006.11
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,009,390,590.73	2,145,752,748.63
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,009,390,590.73	2,145,752,748.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,009,390,590.73	2,145,752,748.63
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	103,350,747.24	103,350,747.24
D09	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,112,741,337.97	2,249,103,495.87

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,134,381,200.0	995,514,434.9	138,866,765.1	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,134,381,200.0	995,514,434.9	138,866,765.1	87.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	987,286,100.0	852,454,094.9	134,832,005.1	86.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,922,300.0	572,416,836.6	108,505,463.4	84.1
210101	Үндсэн цалин	469,040,900.0	386,433,161.4	82,607,738.6	82.4
210102	Нэмэгдэл	171,923,300.0	127,327,278.9	44,596,021.1	74.1
210104	Урамшуулал	14,636,400.0	33,960,796.3	-19,324,396.3	232.0
210105	Гэрээт ажлын хөлс	25,321,700.0	24,695,600.0	626,100.0	97.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,037,200.0	71,587,272.4	13,449,927.6	84.2
210201	Тэтгэврийн даатгал	57,825,300.0	48,192,880.5	9,632,419.5	83.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,803,000.0	5,932,310.6	870,689.4	87.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,442,400.0	4,749,419.6	692,980.4	87.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,600.0	1,414,212.9	-53,612.9	103.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,605,900.0	11,298,448.9	2,307,451.2	83.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,325,900.0	138,493,053.0	10,832,847.0	92.7
210301	Гэрэл, цахилгаан	6,178,900.0	10,916,160.0	-4,737,260.0	176.7
210302	Түлш, халаалт	134,048,100.0	121,317,597.0	12,730,503.0	90.5
210303	Цэвэр, бохир ус	9,098,900.0	6,259,296.0	2,839,604.0	68.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,400,000.0	17,400,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	17,400,000.0	17,400,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,837,900.0	7,692,342.9	145,557.2	98.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,837,900.0	7,692,342.9	145,557.2	98.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,762,800.0	44,864,590.0	1,898,210.0	95.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,006,000.0	33,109,090.0	1,896,910.0	94.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,756,800.0	11,755,500.0	1,300.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,095,100.0	143,060,340.0	4,034,760.0	97.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,095,100.0	143,060,340.0	4,034,760.0	97.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	131,811,100.0	127,776,340.0	4,034,760.0	96.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,284,000.0	15,284,000.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,134,381,200.0	1,122,922,253.0	11,458,947.0	99.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	939,246,400.0	939,246,400.0	00.0	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	939,246,400.0	939,246,400.0	00.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195,134,800.0	183,675,853.0	11,458,947.0	94.1
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,134,800.0	183,675,853.0	11,458,947.0	94.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	127,407,818.1	127,407,818.1	00.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	00.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	38	00.0	100.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27	27	00.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	00.0	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургууль нь 2022-2023 оны хичээлийн жилд “Суралцагчийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжиж боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгах замаар сурах тэгш боломжийг бүрдүүлэн багшлахуйн ур чадварыг хөгжүүлж “Зөвлөх”, “Тэргүүлэх” зэрэгтэй багш нарын манлайллыг нэмэгдүүлэн сурлагын хоцрогдлыг бууруулах” зорилгыг дэвшүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн захирлын 2021 оны 12 сарын 14 өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,249,197.7 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 103,445.0 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	127,407.8	127,407.8
Авлага	786.4	-	(786.4)
Бараа материал	91,008.9	90,184.7	(824.2)
Үндсэн хөрөнгө	2,287,477.3	2,326,017.1	38,539.8
Хуримтлагдсан элэгдэл	(233,519.8)	(294,411.9)	(60,892.1)
Нийт хөрөнгө	2,145,752.7	2,249,197.7	103,445.0
Өр төлбөр	-	94.2	94.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,145,752.7	2,249,103.5	103,350.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,145,752.7	2,249,197.7	103,445.0

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант оны эцэст улсын төсвийн харилцах дансны үлдэгдэл 127,407.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 786.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90,184.7 мянган төгрөг болж өмнөх оноос 824.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 168,651.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 5,627.7 мянга бүгд 174,279.3 мянган төгрөгийн орлого авч 172,804.3 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулж 2,299.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой бөгөөд үүнээс эм боох материал 4,731.8 мянга, бичиг хэргийн материал 705.0 мянга, барилгын засварын материал 5,340.0 мянга, бусад хангамжийн материал 2,299.2 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,326,017.1 мянган төгрөг болж 38,539.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,675.0 мянга, БШУЯ-аас 29,671.8 мянга, НҮБ-ийн хүүхдийн ивээх сангаас 1,193.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд оны эцэст 94.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсадтай холбоотой цалингийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,249,197.7 мянган төгрөг болж 103,350.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 103,350.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 951,471.5 мянга, нийт зарлагыг 951,471.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 180,863.6 мянган төгрөгөөр өсгөж 1,132,335.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,134,381.2 мянган төгрөг болгож 2,046.1 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна. Энэ нь цалин өссөнтэй холбоотой байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81816, 81823, 81834, 81835, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,134,381.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 939,246.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 195,134.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 939,246.4 мянга, орон нутгийн төсвөөс 183,675.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй орон нутгийн төсвийн санхүүжилтээс 11,458.9 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 995,514.4 мянган төгрөг буюу 87.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 138,866.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1,134,381.2	995,514.4	138,866.8	87.8
2	80226 Байр ашиглалтын зардал	3,135.2	3,132.8	2.4	99.9
3	80312 Сургалт семинарын зардал	1,567.6	1,421.5	146.1	90.7
4	81605 Эрүүл мэндийг дэмжих зардал	3,605.4	2,122.0	1,483.4	58.9
5	81801 Үдийн цай хөтөлбөр	131,811.1	127,776.3	4,034.8	96.9
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7,495.0	7,495.0	0.0	100.0
7	81823 Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	7,054.1	6,805.0	249.1	96.5
8	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	691,757.3	580,257.6	111,499.7	83.9
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	92,820.7	82,828.4	9,992.3	89.2
10	80112 Нийтлэг үйлчилгээ	195,134.8	183,675.9	11,458.9	94.1
	Нийт дүн	1,134,381.2	995,514.4	138,866.8	87.8

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн захирал Л.Аюурзана, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Амаржаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,134,381.2 мянган төгрөгөөс тооцоход 17,015.7 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 11,911.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 1,335,476.4 мянган төгрөгийн 151 мэдээллээс 141 мэдээлэл хугацаандаа оруулж 6 мэдээлэл хугацаа хоцроосон, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	4	3	2	2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	4	0		
4	Сар бүр	3	36	33	3		
5	Тухай бүр	8	96	96	0		
	Нийт	27	151	141	6	2	2

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 6,384.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрч зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн ба Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн захирлын 2022.05.24-ны өдрийн 39 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	6,384.6	2	6,384.6	100
Нийт дүн	2	6,384.6	2	6,384.6	100

Эх сурвалж: 2021 оны аудитын тайлангаас

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 онд 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй улмаас Үдийн цайны зардал 4034,7 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,986.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,171,6 мянган төгрөгийн албан шаардлага, 320.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 495.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

2. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлаас Олон улсын Логик пазлын уралдаанд оролцсон 2 багшид томилолтын зардалд 2022.05.25-д 320.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт түүнийг зарцуулах заавар"-ын 5.2.3-т "Аливаа олимпиад, уралдаан тэмцээнд оролцох зардал"-ыг санхүүжүүлэхгүй гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан томилолтын зардлын 320.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Боловсролын мэдээллийн технологийн төвөөс бүх сургууль цэцэрлэгийн интернэтийн төлбөр 100 хувь төлсөн байхад тухайн байгууллага нь тайлант онд 3,171.6 мянган төгрөгийг Мобиком ХХК руу интернэтийн төлбөрт төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3. Зөвлөмж

1. Итгэлт тайж ХХК руу барилгын гүйцэтгэлийн зургийн үнэнд 495.0 мянган төгрөгийг цахим хэрэглээний зардлаас төлсөн байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Цэцэрлэг, ЕБС-ийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4-т "Цахим хэрэглээний зардалд цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай, дата, цахим систем, цахим эрх зэрэг бусад мэдээлэл технологийн ашиглалтын зардал багтана" гэсэн заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Цахим хэрэглээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Баянхонгор аймгийн Баян-Ойт цогцолбор сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим хэрэглээний зардлаас барилгын гүйцэтгэлийн зургийн үнэ шилжүүлсэн байна.	1	495.0					1	495.0				
Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлаас уралдаан тэмцээний зардал зарцуулсан байна	1	320.0	1	320.0								
БМТ-ын төвөөс интернэтийн зардал төлсөн байхад байгууллагын төсвөөс давхардуулан төлсөн байна.	1	3,171.6			1	3,171.6						
Дүн	3	3,986.6	1	320.0	1	3,171.6	1	495.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулахгүй байна.	1	0	0	0	0	0	1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0

ooOoo